



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 02 өдөр

Дугаар A/114

Халбан

**Хоолны зардалын хэмжээг тогтоох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.5, 59.1.23, 66 дүгээр зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Захиргааны ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 29.2, 40 дүгээр зүйлийн 40.2.3 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3, 59 дүгээр зүйлийн 59.1.8, 61 дүгээр зүйлийн 61.1.1, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоол, Хөвсгөл аймгийн Засаг даргын 2023 оны A/457 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засаг даргын орлогч, Засаг даргын Тамгын газрын дарга, бүх багийн Засаг дарга, Санхүүгийн албаны дарга нарт олгох хоолны зардалын хэмжээг ажлын нэг өдөрт 5,000 (таван мянга) төгрөг байхаар тогтоосугай.

2.Албан хаагчдад хоолны нөхөх зардалыг 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн тооцож олохыг Нягтлан бодогч (М.Отгон-Өлзий)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү албаны дарга (Г.Оюунчимэг)-д даалгасугай.

ДАРГА  Н.АНХБАЯР

